



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 37

Эрдэнэт


Концесс олгох уралдаант шалгаруулалт  
зохион байгуулах тухай

“Хот байгуулалтын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Концессын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 7 дугаар зүйлийн 7.2.1, 10 дугаар зүйлийн 10.2 дугаар заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн Ээлжит XVI хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Орхон аймгийн Баян-өндөр сумын Зэст багийн нутагт байрлах 1А хорооллын үерийн хамгаалалт, хатуу хучилттай авто замын барилгын ажлыг орон нутгийн концессын зүйлийн дагуу “барих- ашиглах- шилжүүлэх” төрлөөр концесс олгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахыг Аймгийн Засаг дарга С.Дангаасүрэнд зөвшөөрсүгэй .

2. Энэхүү ажлын төсөв хөрөнгийн асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн Ээлжит XVI хуралдааны 4 дүгээр тогтоолоор батлагдсан Концессын зүйлийн жагсаалттай нэгдмэл байдлаар зохион байгуулахыг аймгийн Засаг дарга С.Дангаасүрэнд даалгасугай.

ДАРГА



Б. МЯГМАРСҮРЭН

C:\Togtool \-A4 doc

001 0487